

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН АЖЛЫН АЛБА, ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ, ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ, ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ, СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ, ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ, БОЛОВСРОЛЫН ЯАМ, ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ, САНГИЙН ЯАМ, БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ, ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ, АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 43 дугаар тэмдэглэлд:

“6.ХЭЛЭЛЦСЭН нь: “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1.“Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 456 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцээд тогтоол гаргахаар тогтов.

2.Төсвийн жилд багтаан барьцаа хөрөнгийн данснаас чөлөөлөх боломжгүй, хэрэгжилт удаашралтай, зогссон төслүүдийн гэрээг дүгнэж, эцсийн тооцоог баталгаажуулан барьцаа хөрөнгийн данс дахь санхүүжилтийн үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэхийг төсвийн холбогдох ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР